ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2026/107/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дундговь аймаг<br>2026 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох<br>Утас: 70592439<br>Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Т.Батсайхан<br>Утас: 70592225<br>Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn<br><br>Аудитыг гүйцэтгэсэн: Азуре Хүлүг Аудит ХХК<br>Утас: 70110090<br>Цахим хаяг: audit@azure.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 8
3.1 Төлбөрийн акт ..... 8
3.2 Албан шаардлага ..... 8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 10

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.24 № 47

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.БОЛОРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 108,586.0 мянган төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

4826050154

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 85.7 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **318,714,406.27** | **430,434,715.95** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **170,977,828.65** | **275,145,712.71** |
| **311** | **Кассад байгаа бэлэн мөнгө** | **-** | **-** |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **170,977,828.65** | **275,145,712.71** |
| **3121** | **Төгрөг** | **170,977,828.65** | **275,145,712.71** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 155,745,955.65 | 275,145,712.71 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 15,231,873.00 | - |
| **33** | **АВЛАГА** | **-** | **13,313,173.00** |
| **335** | **Бусад авлага** | **-** | **13,313,173.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 13,313,173.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **147,736,577.62** | **141,975,830.24** |
| **351** | **Түүхий эд материал** | **105,379,948.12** | **109,487,295.74** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 104,072,448.12 | 108,328,295.74 |
| 35130 | Эм боох материал | 1,307,500.00 | 1,159,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **40,426,629.50** | **30,948,534.50** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,274,950.00 | 3,591,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,618,581.00 | 8,223,251.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,675,400.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 10,834,948.50 | 8,000,948.50 |
| 35460 | Хүнсний материал | 9,022,750.00 | 11,132,635.00 |
| 35600 | Мал амьтад | 1,930,000.00 | 1,540,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,914,289,068.76** | **1,933,743,043.90** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,914,289,068.76** | **1,933,743,043.90** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,866,392,668.76** | **1,885,846,643.90** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,607,070,335.16 | 1,631,707,355.16 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (122,329,974.79) | (150,075,942.11) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 35,500,000.00 | 35,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (9,861,111.02) | (12,227,777.66) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 268,897,372.47 | 337,136,462.47 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (64,743,307.08) | (102,246,035.02) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 96,539,447.00 | 104,884,022.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,969,610.03) | (28,940,957.99) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 62,894,800.00 | 62,894,800.00 |
| 39217 | Ном | 6,394,717.06 | 7,214,717.06 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **47,896,400.00** | **47,896,400.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 47,896,400.00 | 47,896,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,233,003,475.03** | **2,364,177,759.85** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **27,187,806.00** | **12,251,500.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **27,187,806.00** | **12,251,500.00** |
| **413** | **Өглөг** | **27,187,806.00** | **12,251,500.00** |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 11,668,806.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | **15,519,000.00** | **12,251,500.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 15,519,000.00 | 12,251,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,205,815,669.03** | **2,351,926,259.85** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,205,815,669.03 | 2,351,926,259.85 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 932,879,876.77 | 932,879,876.77 |
| 51101 | Өмч: - төрийн | 932,879,876.77 | 932,879,876.77 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **457,352,680.18** | **603,463,271.00** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 457,352,680.18 | 434,033,886.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 169,429,384.82 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 815,583,112.08 | 815,583,112.08 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,233,003,475.03** | **2,364,177,759.85** |

## 2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,585,699,196.41** | **1,694,360,969.62** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **238,951,896.41** | **165,192,169.62** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 238,951,896.41 | 165,192,169.62 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 29,349,645.00 | 11,610,050.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 808,200.00 | 808,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 28,541,445.00 | 10,801,850.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 168,055,636.97 | 148,461,812.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 41,546,614.44 | 5,120,307.62 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,346,747,300.00** | **1,529,168,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,189,253,300.00 | 1,367,944,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,189,253,300.00 | 1,367,944,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 157,494,000.00 | 161,224,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 157,494,000.00 | 161,224,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,297,858,404.85** | **1,503,063,075.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,297,858,404.85** | **1,503,063,075.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,295,481,113.75 | 1,492,408,602.14 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 858,801,236.63 | 967,387,201.94 |
| 210101 | Үндсэн цалин | 548,945,633.00 | 577,230,932.94 |
| 210102 | Нэмэгдэл | 272,709,243.63 | 317,885,259.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 28,270,000.00 |
| 210104 | Урамшуулал | 37,146,360.00 | 44,001,010.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 101,035,822.89 | 118,890,966.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,935,346.69 | 82,253,625.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,882,989.25 | 9,599,300.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,761,123.61 | 5,293,980.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,009,389.04 | 4,270,407.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,446,974.30 | 17,473,651.47 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 145,713,408.90 | 149,518,276.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,885,493.90 | 14,490,361.60 |
| 210302 | Түлш, халаалт | 129,827,915.00 | 129,827,915.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,000,000.00 | 5,200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,339,833.00 | 27,331,910.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,923,183.00 | 4,568,730.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,202,300.00 | 5,478,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,214,350.00 | 11,965,480.00 |
| 210408 | Бараа материал актлалсны зардал | - | 5,319,000.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 61,253,806.00 | 79,556,285.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 154,400.00 | 1,148,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 61,099,406.00 | 78,407,785.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,081,900.00 | 8,752,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,081,900.00 | 8,752,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,681,213.09 | 10,996,668.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 808,200.00 | 808,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,873,013.09 | 10,188,468.20 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 92,573,893.24 | 129,974,794.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,281,901.00 | 7,485,266.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,485,700.00 | 6,198,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 80,806,292.24 | 116,290,827.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,377,291.10 | 10,654,473.40 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 9,123,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 9,123,800.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,377,291.10 | 1,530,673.40 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,377,291.10 | 1,530,673.40 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **287,840,791.56** | **191,297,894.08** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,260,000.00 | 21,868,509.26 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 21,868,509.26 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 2,260,000.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (2,260,000.00) | (21,868,509.26) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **285,580,791.56** | **169,429,384.82** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,376,096,945.00** | **1,540,778,850.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **29,349,645.00** | **11,610,050.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 29,349,645.00 | 11,610,050.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 29,349,645.00 | 11,610,050.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 808,200.00 | 808,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 28,541,445.00 | 10,801,850.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,346,747,300.00** | **1,529,168,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,189,253,300.00 | 1,367,944,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,189,253,300.00 | 1,367,944,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 157,494,000.00 | 161,224,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 157,494,000.00 | 161,224,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,226,743,599.89** | **1,427,459,465.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,226,743,599.89** | **1,427,459,465.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,198,016,378.79** | **1,374,203,919.54** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 857,218,629.91 | 967,387,201.94 |
| 210101 | Үндсэн цалин | 547,363,026.28 | 564,591,151.80 |
| 210102 | Нэмэгдэл | 272,709,243.63 | 319,609,553.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 28,265,000.00 |
| 210104 | Урамшуулал | 37,146,360.00 | 54,921,497.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 101,679,268.89 | 118,890,966.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,597,349.16 | 82,253,625.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,878,350.12 | 9,599,300.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,820,415.03 | 5,293,980.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,015,506.06 | 4,270,407.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,367,648.52 | 17,473,651.47 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 146,313,408.90 | 182,908,276.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,885,493.90 | 14,490,361.60 |
| 210302 | Түлш, халаалт | 130,427,915.00 | 163,217,915.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,000,000.00 | 5,200,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 37,623,880.00 | 43,602,570.00 |
| 210502 | Хоол, хүнс | 37,623,880.00 | 43,602,570.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,310,300.00 | 10,393,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,310,300.00 | 10,393,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,202,923.09 | 14,213,668.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 808,200.00 | 808,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,394,723.09 | 13,405,468.20 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 31,667,968.00 | 36,808,136.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,505,768.00 | 30,609,436.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,162,200.00 | 6,198,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,727,221.10** | **53,255,546.40** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,349,930.00 | 38,932,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,349,930.00 | 29,808,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 9,123,800.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,377,291.10 | 14,323,046.40 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,377,291.10 | 14,323,046.40 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **149,353,345.11** | **113,319,384.06** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,439,800.00** | **9,151,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,439,800.00** | **9,151,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,439,800.00 | 9,151,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,439,800.00 | 9,151,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(10,439,800.00)** | **(9,151,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 138,913,545.11 | 104,167,884.06 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 32,064,283.54 | 170,977,828.65 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 170,977,828.65 | 275,145,712.71 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 932,879,876.77 | 815,583,112.08 | 172,771,888.62 | 1,921,234,877.47 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 285,580,791.56 | 285,580,791.56 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **932,879,876.77** | **815,583,112.08** | **458,352,680.18** | 2,206,815,669.03 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (23,318,794.00) | (23,318,794.00) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **932,879,876.77** | **815,583,112.08** | **435,033,886.18** | 2,183,496,875.03 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 169,429,384.82 | 169,429,384.82 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **932,879,876.77** | **815,583,112.08** | **604,463,271.00** | 2,352,926,259.85 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| **Татаас, санхүүжилтийн орлого** | **1,562,044,200.00** | **1,529,168,800.00** | **32,875,400.00** |
| Улсын төсвөөс | 1,370,651,600.00 | 1,337,776,200.00 | 32,875,400.00 |
| Орон нутгийн төсвөөс | 191,392,600.00 | 191,392,600.00 | - |
| **Бараа, үйлчилгээний орлого** | **30,631,700.00** | **11,610,050.00** | **19,021,650.00** |
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 30,631,700.00 | 11,610,050.00 | 19,021,650.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,592,675,900.00** | **1,540,778,850.00** | **254,899,700.00** |
| **Ажиллагчидтай холбогдсон зардал** | **1,221,931,600.00** | **1,086,278,167.94** | **135,653,432.06** |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,086,160,700.00** | **967,387,201.94** | **118,773,498.06** |
| Цалин | 1,086,160,700.00 | 967,387,201.94 | 118,773,498.06 |
| **Нийгмийн хамгааллын шимтгэл** | **135,770,900.00** | **118,890,966.00** | **16,879,934.00** |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 135,770,900.00 | 118,890,966.00 | 16,879,934.00 |
| **Бараа, үйлчилгээний урсгал зардал** | **370,744,300.00** | **335,100,925.00** | **35,643,375.00** |
| Гэрэл цахилгааны зардал | 11,604,200.00 | 14,490,361.60 | (2,886,161.60) |
| Түлш, халаалтын зардал | 167,154,400.00 | 163,217,915.00 | 3,936,485.00 |
| Цэвэр, бохир усны зардал | 5,200,000.00 | 5,200,000.00 | - |
| Хоол | 43,826,300.00 | 43,602,570.00 | 223,730.00 |
| Эм | | | - |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 116,439,800.00 | 82,611,378.40 | 33,828,421.60 |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 6,461,800.00 | 6,461,800.00 | - |
| Урсгал засварын зардал | 10,934,000.00 | 10,393,100.00 | 540,900.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 9,123,800.00 | 9,123,800.00 | - |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **1,592,675,900.00** | **1,421,379,092.94** | **171,296,807.06** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 155,745,955.65 | - |

| | | | |
|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 263,535,662.71 | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,123.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 123.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 1,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага тус тус хүргүүллээ.

### 3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Аудитаар 2025 оны 09 сарын 19-ний ажил гүйлгээгээр 15 багшид бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-т (*төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*) 15.1.3-т (*төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д (*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*) заасныг тус тус хэрэгжүүлээгүй мөн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 123,750 (нэг зуун хорин гурван мянга долоон зуун тавь) мянган төгрөгийн шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх*

### 3.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Аудитаар хууль тогтоомж зөрчиж сургуулийн багш ажилчдын сургалтын төлбөрт 1,000.00 төгрөгийг шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д (*сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх*), Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны 05 тоот албан даалгавар 1.4-д (*тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах*), 1.4.1-т (*хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод, гадаад томилолт, тээвэр шатахуун, зочин, төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д (*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*) заасныг тус тус хэрэгжүүлээгүй мөн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.*

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100.0 хувийг залруулагдаагүй алдаа эзэлж байна. Нийт 1,123.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Үүнээс завсрын аудитаар илэрсэн 123.7 мянган төгрөгийн төлбөрийн актыг төлж барагдуулсан учраас дүгнэлтийн материаллаг байдалд нөлөөлөхгүй. Харин жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 1,000.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 13,906.9 мянган төгрөгөөр бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2025 оны 09 сарын 19-ний ажил гүйлгээгээр 15 багшид бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна. | 1 | 123.7 | 1 | 123.7 | - | - | | | | |
| Аудитаар хууль тогтоомж зөрчиж сургуулийн багш ажилчдын сургалтын төлбөрийг шилжүүлсэн зөрчил илэрлээ. | 1 | 1,000.0 | - | - | 1 | 1,000.0 | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **1,123.7** | **1** | **123.7** | **1** | **1,000.00** | **-** | **-** | **-** | **-** |